



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2024/13/НА-СТА-ОНА

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Баянхонгор хот

2024 оны 03 дугаар сар

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын  
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат  
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Ахлах аудитор М.Алтантуяа  
Утас: 70442424 Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Азбаяр  
Утас: 99061429 Цахим хаяг: Azbayarb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	/төгрөгөөр/ .. 4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан .....	/төгрөгөөр/ .. 5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	/төгрөгөөр/ ... 6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	/төгрөгөөр/ 6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	/төгрөгөөр/ .. 7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	8
3.1 Компанийн үйл ажиллагаа .....	8
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	9
4. Аудитын тайлан .....	12
4.1 Ерөнхий зүйл .....	12
4.2 Дотоод хяналт .....	12
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
4.4 Материаллаг байдал .....	13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
5.1 Шилэн дансны мэдээлэл .....	13
6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
8. Аудитын илрүүлэлт.....	14
8.1. Албан шаардлага .....	14
8.3 Зөвлөмж.....	<b>Error! Bookmark not defined.</b>
9. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	14

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2024.03.15 № 2/86  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянхонгор аймгийн Үйлдвэржилт хөгжлийн корпорацийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Үйлдвэржилт хөгжлийн корпорацийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

2023 онд нийт цэвэр борлуулалт нь 199,915.3 мянган төгрөг борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 333,480.9 мянган төгрөгийн зардалтай, Ерөнхий ба удирдлагын зардалд 126,111.6 төгрөгийн зардалтай, үйл ажиллагааны бус зардалд орлого зардлын зөрүүгээр 130,987.9 мянган төгрөгийн олз гарч дүнгээр 228,689.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

5020326

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 нийтлэг зорилт, арга хэмжээний хүрээнд 8 зорилт, 69 арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд хангалттай сайн дүгнэгдсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан.

### **Удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,122,798,281.42</b>	<b>1,881,939,006.82</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>129,140,149.60</b>	<b>75,060,736.52</b>
<b>31100</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	<b>920,000.00</b>	<b>1,222,350.27</b>
31110	Төгрөг	920,000.00	1,222,350.27
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>128,220,149.60</b>	<b>73,838,386.25</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>128,220,149.60</b>	<b>73,838,386.25</b>
31213	Арилжааны банк дахь харилцах	128,220,149.60	73,838,386.25
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>1,992,920,499.71</b>	<b>1,804,952,238.43</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	9,194,357.69	19,079,851.14
33401	Дансны авлага /ТӨҮГ/	55,000.00	55,000.00
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>26,588.00</b>	<b>18,435.27</b>
33510	Байгууллагаас авах авлага	26,588.00	18,435.27
<b>33600</b>	<b>Зээлийн авлага</b>	<b>1,983,644,554.02</b>	<b>1,785,798,952.02</b>
<b>33610</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	<b>1,983,644,554.02</b>	<b>1,785,798,952.02</b>
33612	Хувь хүмүүст олгосон зээл	1,983,644,554.02	1,785,798,952.02
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>737,632.11</b>	<b>1,926,031.87</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>737,632.11</b>	<b>1,926,031.87</b>
35410	Бичиг хэргийн материал	57,979.20	536,950.99
35420	Аж ахуйн материал	45,777.63	51,231.69
35440	Түлш, шатах тослох материал	633,875.28	1,337,849.19
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,435,502,733.68</b>	<b>3,243,284,449.99</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,435,502,733.68</b>	<b>3,243,284,449.99</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>3,324,292,733.68</b>	<b>3,113,574,449.99</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,083,245,203.33	4,083,245,203.33
39202	Хуримтлагдсан элэгдэл	-830,488,283.60	-
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	93,877,387.94	90,328,993.39
39206	Хуримтлагдсан элэгдэл	-79,202,663.98	-86,883,628.99
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,879,090.00	28,788,180.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,021,380.01	-11,219,013.93
39214	Бусад үндсэн хөрөнгө	45,003,380.00	45,003,380.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	0	-287,878.78
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>111,210,000.00</b>	<b>129,710,000.00</b>
39301	Програм хангамж	1,000,000.00	1,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-750,000.00	-750,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	110,960,000.00	129,460,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>5,558,301,015.10</b>	<b>5,125,223,456.81</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,258,436,802.09</b>	<b>2,035,548,538.26</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>196,081,302.09</b>	<b>217,590,448.26</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>42,948,598.21</b>	<b>50,546,636.88</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>42,948,598.21</b>	<b>50,546,636.88</b>

41363	Татварын өглөг /ТӨҮГ/	41,469,658.19	50,535,491.60
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	1,478,940.02	11,145.28
<b>41400</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>153,132,703.88</b>	<b>167,043,811.38</b>
41440	Бусад урьдчилж орсон орлого	153,132,703.88	167,043,811.38
<b>42</b>	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,062,355,500.00</b>	<b>1,817,958,090.00</b>
<b>42200</b>	<b>Урт хугацаат зээл</b>	<b>2,062,355,500.00</b>	<b>1,817,958,090.00</b>
<b>42210</b>	<b>Төгрөг</b>	<b>2,062,355,500.00</b>	<b>1,817,958,090.00</b>
42212	Хувь хүмүүсийн зээл	2,062,355,500.00	1,817,958,090.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,299,864,213.01</b>	<b>3,089,674,918.55</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,299,864,213.01</b>	<b>3,089,674,918.55</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	4,332,186,922.36	4,350,686,922.36
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	4,332,186,922.36	4,350,686,922.36
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,032,322,709.35</b>	<b>1,261,012,003.81</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-700,014,289.02	1,032,322,709.35
51220	Тайлант үеийн үр дүн	-332,308,420.33	-228,689,294.46
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>5,558,301,015.10</b>	<b>5,125,223,456.81</b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>121,886,920.69</b>	<b>230,903,212.24</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>121,886,920.69</b>	<b>230,903,212.24</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>121,886,920.69</b>	<b>230,903,212.24</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>121,886,920.69</b>	<b>230,903,212.24</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	121,886,920.69	199,915,311.34
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	30,987,900.90
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>454,195,341.02</b>	<b>458,894,118.29</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>454,195,341.02</b>	<b>458,894,118.29</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>454,195,341.02</b>	<b>458,894,118.29</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>454,195,341.02</b>	<b>458,894,118.29</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	221,140,527.70	240,965,132.16
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	233,054,813.32	217,928,986.13
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-332,308,420.33</b>	<b>-227,990,906.05</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0</b>	<b>698,388.41</b>
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	0	698,388.41
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-332,308,420.33</b>	<b>-228,689,294.46</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>709,806,570.00</b>	<b>797,973,276.31</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>709,806,570.00</b>	<b>797,973,276.31</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>709,806,570.00</b>	<b>797,973,276.31</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>709,806,570.00</b>	<b>797,973,276.31</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	168,426,631.00	251,308,502.32
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	541,379,939.00	546,664,773.99
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>855,851,082.50</b>	<b>844,143,598.49</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>855,851,082.50</b>	<b>844,143,598.49</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>855,851,082.50</b>	<b>844,143,598.49</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>86,687,032.50</b>	<b>92,041,317.00</b>
210101	Үндсэн цалин	86,687,032.50	92,041,317.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>25,637,588.45</b>	<b>26,374,763.01</b>
210201	Тэтгэврийн даатгал	25,637,588.45	26,374,763.01
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>743,526,461.55</b>	<b>725,727,518.48</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	743,526,461.55	725,727,518.48
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>-146,044,512.50</b>	<b>-46,170,322.18</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>6,835,000.00</b>	<b>7,909,090.90</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,835,000.00</b>	<b>7,909,090.90</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>6,835,000.00</b>	<b>7,909,090.90</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,835,000.00	7,909,090.90
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-6,835,000.00</b>	<b>-7,909,090.90</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-152,879,512.50</b>	<b>-54,079,413.08</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	282,019,662.10	129,140,149.60
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	129,140,149.60	75,060,736.52

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,332,186,922.36	0.00	-700,014,289.02	3,632,172,633.34
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,332,186,922.36	0.00	-700,014,289.02	3,632,172,633.34
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00

8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-332,308,420.33	-332,308,420.33
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,332,186,922.36	0.00	-1,032,322,709.35	3,299,864,213.01
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,332,186,922.36	0.00	-1,032,322,709.35	3,299,864,213.01
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,332,186,922.36	0.00	-1,032,322,709.35	3,299,864,213.01
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	18,500,000.00	0.00	0.00	18,500,000.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-228,689,294.46	-228,689,294.46
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,350,686,922.36	0.00	-1,261,012,003.81	3,089,674,918.55

## 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Зардлын үзүүлэлт	2023 оны Зардлын гүйцэтгэлийн төлөвлөлт	2023 оны гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт	биелэлтийн хувь
Цалин	122,880,000	109,976,007	12,903,993	89.5
Үр дүн урамшуулал	3,087,000	0	3,087,000	-
ЭМД, НДШ	15,745,875	13,662,813	2,083,062	86.8
Албан томилот	742,000	0	742,000	-
Элэгдлийн зардал	233,609,581	217,928,986	15,680,595	93.3
тэтгэмж шагнал урамшуулал	2,100,000	200,000	1,900,000	9.5
ТУЗ урамшуулал	6,800,000	4,170,000	2,630,000	61.3
ТУЗ бусад зардал	500,000	95,884	404,116	19.2
ТУЗ бичиг хэргийн зардал	150,000	0	150,000	-
Цахилгааны зардал	38,978,639	29,974,192	9,004,447	76.9
Нүүрсний зардал	16,560,000	9,678,563	6,881,437	58.4
Халаалтын зардал	39,679,860	37,357,437	2,322,423	94.1
хог тээврийн зардал	1,440,000	853,578	586,422	59.3
Цэвэр бохир усны зардал	2,382,336	2,439,834	-57,498	102.4

Шуудан холбооны зардал	1,340,000	815,100	524,900	60.8
Бичиг хэргийн зардал	3,993,000	2,344,310	1,648,690	58.7
Шатахууны зардал	5,640,000	5,136,037	503,963	91.1
хангамжийн материалын зардал	1,327,000	1,263,790	63,210	95.2
Ариутгал цэвэрлэгээ	3,877,000	1,144,118	2,732,882	29.5
БГАҮ зардал	1,600,000	1,029,800	570,200	64.4
Бусад зардал	6,075,000	5,178,288	896,712	85.2
зар сурталчилгаа	500,000	0	500,000	-
сургалт	500,000	0	500,000	-
газрын төлбөр	428,000	429,072	-1,072	100.3
татвар	10,000,000	0	10,000,000	-
Засвар үйлчилгээний зардал	6,500,000	0	6,500,000	-
Урсгал засвар	12,220,000	2,953,818	9,266,182	24.2
Сэлбэгийн зардал	2,000,000	939,636	1,060,364	47.0
Гамшгийн нөөцийн зардал	2,055,500	0	2,055,500	-
Хөдөлмөр хамгаалал	2,539,000	1,857,182	681,818	73.1
Бодлого төлөвлөлтийн Хяналтын зардал	8,000,000	10,439,945	-2,439,945	130.5
Бодлого төлөвлөлтийн бусад зардал	5,000,000	0	5,000,000	-
Бодлого төлөвлөлтийн томилолтын зардал	2,544,000	0	2,544,000	-
Дүн	560,793,791	459,868,390	100,925,401	82.0

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.

#### 3.1 Компанийн үйл ажиллагаа

“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн зорилго нь “Аймгийн эдийн засгийн хөгжлийн стратеги бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэх зорилгоор төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, бизнесийн орчныг дэмжих замаар зах зээлийг өргөжүүлэн, ажлын байрыг нэмэгдүүлэх”-д оршино.

Тус байгууллага гүйцэтгэх захирал, захиргаа хүний нөөцийн албаны 3, бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны албаны 3, үйлчилгээний 8, нийт 15 албан хаагчтай үйл ажиллагаа явуулж, жижиг дунд үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, газар тариалан эрхлэгчдийг сургах, хөгжүүлэх дэмжлэг үзүүлэх, холбон зуучлах, удирдлага арга зүйгээр ханган ажилладаг байна.

#### 3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Тус компанийг аймгийн ИТХ-ын Хуралдааны 2016.10.11-ний өдрийн тогтоолоор байгуулсан ба байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд “Хязгаарлагдмал Аудитын код: БНА-2023/8/НА-СТА-ОНӨААН

хариуцлагатай компани” гэсэн статустай, өмчийн 100 хувийг орон нутгийн өмч эзэмшиж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3 дахь заалтад “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасан ба тогтоолыг зөрчсөн асуудал байхгүй байна.

Тус компани нь тайлант онд 246,414.5 мянган төгрөгийн орлого оруулж, 560,793.8 мянган төгрөгийн зардалтай төсөв батлагдсан ба үүнээс 233,609.6 мянган төгрөг нь элэгдлийн зардал байгаа ба тайлант онд 228,689.3 мянган төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

Тайлант хугацаанд компанийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
1.1.01	Мөнгөн хөрөнгө	129,140.1	75,060.7	-54,079.4
	Авлага	1,992,920.5	1,804,952.2	-187,968.3
1.1.06	Бараа материал	737.6	1,926.0	1,188.4
1.1.11	<b>эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2,122,798.3</b>	<b>1,881,939.0</b>	<b>-240,859.3</b>
1.2.01	Үндсэн хөрөнгө	3,324,292.7	3,113,574.4	-210,718.3
1.2.02	Биет бус хөрөнгө	111,210.0	129,710.0	18,500.0
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>3,435,502.7</b>	<b>3,243,284.4</b>	<b>-192,218.3</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,558,301.0</b>	<b>5,125,223.5</b>	<b>-433,077.6</b>
	Өр төлбөр	42,948.6	50,546.6	7,598.0
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	2,215,488.2	1,985,001.9	-230,486.3
2.2	<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>2,258,436.8</b>	<b>2,035,548.5</b>	<b>-222,888.3</b>
2.03.01	Өмч- төрийн	4,220,427.9	4,220,427.9	0.0
2.03.08	Эздийн өмчийн бусад хэсэг	111,759.0	130,259.0	18,500.0
2.03.09	Хуримтлагдсан ашиг	-1,032,322.7		1,032,322.7
2.03.09.1	Тайлангийн үеийн алдагдал		-228,689.3	-228,689.3
2.3.09.2	Өмнөх үеийн алдагдал		-1,032,322.7	-1,032,322.7
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>3,299,864.2</b>	<b>3,089,674.9</b>	<b>-210,189.3</b>
2.4	<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>5,558,301.0</b>	<b>5,125,223.4</b>	<b>-433,077.6</b>

Эх сурвалж: “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан данс нь мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөрийн данс байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 75,060.7 мянган төгрөг болж 54,079.4 мянган төгрөгөөр буурсан ба зээлийн эргэн төлөлтийн орлого төвлөрүүлдэг арилжааны банкны үлдэгдэл 39,784.8 мянга, бусад үйл ажиллагааны орлого, зардлын дансанд 35,275.9 мянган төгрөг байршиж байна.

Авлага дансны үлдэгдэл 1,804,952.2 мянган төгрөг болж 187,968.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 582,000.0 мянган төгрөгийн зээл олгож зээлийн авлага 197,845.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Зээлийн авлага нь 151 зээлдэгчийн 1,784,537.5 мянган төгрөгийн үлдэгдэл байгаагаас 685,255.3 мянган төгрөгийн зээл хугацаа хэтэрснийг хууль, хяналтын байгууллагад бүрэн шилжүүлсэн ба шийдвэрлүүлэх ажиллагаа хийгдэж байна.

Түрээслэгч нараас авах түрээсийн төлбөрийн авлага оны эхэнд 9,194.4 мянган төгрөг байсан бол оны эцэст авлага өсөж, 19,079.9 мянган төгрөгийн авлагатай гарсан ба үүнээс 8,283.7 мянган төгрөг нь ажилсаг төвийн түрээслэгчтэй холбоотой, 10,796.2 мянган төгрөг нь ахуйн үйлчилгээний төвийн түрээслэгчтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,926.0 мянган төгрөг болж 1,188.4 мянган төгрөгөөр өссөн нь хангамжийн материал нөөцөлсөнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 50,546.6 мянган төгрөг болж 7,598.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хувь хүний орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татварыг дутуу шилжүүлсэнтэй холбоотой үүссэн байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 3,089,674.8 мянган төгрөг болж 210,189.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн алдагдал байна.

### 3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Компанийн төлөөлөн удирдан зөвлөл “Байгууллагын бизнес төлөвлөгөө”-г 2023.01.15-нд анх баталж, 2023.07.01-ний өдөр өөрчлөлт оруулсан байна.

Тайлант оны борлуулалтын орлогыг 246,414.5 мянга, үйл ажиллагааны бус орлогыг 1,700.0 мянга, нийт 248,114.5 мянган төгрөгөөр, нийт зардлыг 560,793.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр борлуулалтын орлогыг 25,499.2 мянган төгрөгөөр тасарч, 220,915.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 459,868.4 мянган төгрөгийн зардал гаргаснаас 217,929.0 мянган төгрөг нь элэгдлийн зардал байна.

Тайлант онд оруулахаар төлөвлөсөн орлогоос Ажилсаг төвийн түрээсийн орлогыг төлөвлөснөөс 8,433.3 мянга, , Ахуйн үйлчилгээний төвийн түрээсийн орлогыг 11,067.6 мянган төгрөгөөр давуулсан бөгөөд нийт орлогын гүйцэтгэл 222,250.3 мянган төгрөг болж төлөвлөснөөс 25,250.3 мянган төгрөг буюу 10.4 хувиар тасарсан нь төсөл боловсруулсны орлого 365.0 мянган төгрөгөөр бусад орлогоор 45,000.0 мянган төгрөгийн орлого оруулахаас 45,000.0 мянган төгрөг дутуу оруулсан зэрэгтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
1	Төсөл хөтөлбөр боловсруулах	1,700.00	1,335.00	-365.00	78.5	
2	Түрээсийн орлого	Ажилсаг төв	104,549.67	112,982.97	8,433.30	108.1
		Ахуйн үйлчилгээ	75,864.78	86,932.34	11,067.56	114.6

3	ОН санхүүгийн дмжлэг	66000	21,000.00	-45,000.00	31.8
<b>Борлуулалтын дүн</b>		<b>248,114.45</b>	<b>222,250.31</b>	<b>-25,864.14</b>	<b>89.6</b>

Эх сурвалж: Компанийн 2023 оны санхүүгийн тайлан

Нийт зардлын гүйцэтгэл 459,868.4 мянган төгрөг буюу төлөвлөснөөс 100,925.4 мянган төгрөгөөр зардлыг хэмнэсэн байна.

Тус компанийн орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Хүснэгт 3. 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин /мянган төгрөг/

Зардлын үзүүлэлт	2023 оны Зардлын гүйцэтгэлийн төлөвлөлт	2023 оны гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт	биелэлт-ын хувь
Цалин	122,880,000	109,976,007	12,903,993	89.5
Үр дүн урамшуулал	3,087,000	0	3,087,000	-
ЭМД, НДШ	15,745,875	13,662,813	2,083,062	86.8
Албан томилолт	742,000	0	742,000	-
Элэгдлийн зардал	233,609,581	217,928,986	15,680,595	93.3
тэтгэмж шагнал урамшуулал	2,100,000	200,000	1,900,000	9.5
ТУЗ урамшуулал	6,800,000	4,170,000	2,630,000	61.3
ТУЗ бусад зардал	500,000	95,884	404,116	19.2
ТУЗ бичиг хэргийн зардал	150,000	0	150,000	-
Цахилгааны зардал	38,978,639	29,974,192	9,004,447	76.9
Нүүрсний зардал	16,560,000	9,678,563	6,881,437	58.4
Халаалтын зардал	39,679,860	37,357,437	2,322,423	94.1
хог тээврийн зардал	1,440,000	853,578	586,422	59.3
Цэвэр бохир усны зардал	2,382,336	2,439,834	-57,498	102.4
Шуудан холбооны зардал	1,340,000	815,100	524,900	60.8
Бичиг хэргийн зардал	3,993,000	2,344,310	1,648,690	58.7
Шатахууны зардал	5,640,000	5,136,037	503,963	91.1
хангамжийн материалын зардал	1,327,000	1,263,790	63,210	95.2
Ариутгал цэвэрлэгээ	3,877,000	1,144,118	2,732,882	29.5
БГАҮ зардал	1,600,000	1,029,800	570,200	64.4
Бусад зардал	6,075,000	5,178,288	896,712	85.2
зар сурталчилгаа	500,000	0	500,000	-
сургалт	500,000	0	500,000	-
газрын төлбөр	428,000	429,072	-1,072	100.3
татвар	10,000,000	0	10,000,000	-

Засвар үйлчилгээний зардал	6,500,000	0	6,500,000	-
Урсгал засвар	12,220,000	2,953,818	9,266,182	24.2
Сэлбэгийн зардал	2,000,000	939,636	1,060,364	47.0
Гамшгийн нөөцийн зардал	2,055,500	0	2,055,500	-
Хөдөлмөр хамгаалал	2,539,000	1,857,182	681,818	73.1
Бодлого төлөвлөлтийн Хяналтын зардал	8,000,000	10,439,945	-2,439,945	130.5
Бодлого төлөвлөлтийн бусад зардал	5,000,000	0	5,000,000	-
Бодлого төлөвлөлтийн томилолтын зардал	2,544,000	0	2,544,000	-
Дүн	560,793,791	459,868,390	100,925,401	82.0

Эх сурвалж: “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн 2023 оны орлого, зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

## 4. Аудитын тайлан

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг захирал н.Наранбаяр танд танилцуулж байна

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр ирүүлсэн байна.

Тайлант жилд хөрөнгө зарцуулах нэгдүгээр гарын үсгийг н.Наранбаяр, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч А.Одгэрэл нар зурсан байна.

### 4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Олон улсын стандарт дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодогчоор ажиллаж байсан Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогч В.Наранцэцэг боловсруулж, компанийн захирлын 2017.06.28 өдрийн 05 дугаар тушаалаар баталж, одоог хүртэл мөрдөж ажиллаж байна.

### **4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **4.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 459,868.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,598.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,219.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан санхүүгийн тайлангийн аудитын системийн дагуу оруулбал зохих мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад байршуулбал зохих мэдээллийг бүрэн байршуулсан байна.

### **5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь дутуу, хугацаа хоцроосон мэдээлэл их, өмнөх оны аудитын зөвлөмжийн биелүүлээгүй тул Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж үзлээ.

## **6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх онд тус компанид санхүүгийн тайлангийн аудитаар 1,718.5 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илэрснээс, 1,718.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан

шаардлага хүргүүлж, зөрчил давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4.Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	0
Албан шаардлага	1	1,718.5	1	1,718.5	100.0
Зөвлөмж	1	0	1	0	100.0
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>1,718.5</b>	<b>2</b>	<b>1,718.5</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Шийдвэрийн биелэлт гаргасан хуудас, зээлийн мэдээлэл

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 138,557.0 мянган төгрөгийн 1 алдаа зөрчил илэрсэнд 1 албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн материаллаг алдаа нь гүйцэтгэлийн шатанд тооцсон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн боловч материаллаг бус тул "Зөрчилгүй" санал дүгнэлт өгөв.

### 8.1. Албан шаардлага

8.1.1. Хөнгөлөлттэй зээл авсан нийт 30 иргэний 138,557.0 мянган төгрөгийн зээл, зээлийн хүү хугацаа хэтэрсэн байна.

Энэ нь Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 13.2.8-т заасан "Сангаас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, зээлийн гэрээний үүргээ биелүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөнгөлөлттэй зээлийн хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн зөрчлийг санд бүрэн төвлөрүүлж, насжилт үүсэж буй зээлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 9. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөнгөлөлттэй зээл авсан нийт 30 иргэний 138,557.0 мянган төгрөгийн зээл, зээлийн хүү хугацаа хэтэрсэн байна.	1	138,557.0			1	138,557.0		
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>138,557.0</b>			<b>1</b>	<b>138,557.0</b>		<b>-</b>